

ОХУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2007 ОНЫ БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Ж.Орхон*

Өнгөрөгч он ОХУ-ын хувьд эдийн засгийн хөгжлийн хурдацтай жил байсан бөгөөд энэ нь юун туруунд дотоодын хэрэгцээний хангалттай холбоотой. Дотоодын хэрэгцээ нь аж үйлдвэрийн өсөлт дагуулдаг бөгөөд эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болсон худалдаа үүнд том үүрэг гүйцэтгэсэн гэж хэлж болох юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин эдийн засгийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлсэн талаар Холбооны Зөвлөлийн хуралд явуулсан илгээлтдээ “Хамтын хүчин чармайлтаар бид хэд хэдэн чиглэлд ахиц гаргаж чадлаа. Аажимдаа ард иргэдийн амьжиргааны түвшин өссөөр байна. Хүмүүсийн өмнө өөрийнхөө нөөц бололцоогоо нээх боломж ихээхэн нээгдээд зогсохгүй тэд улс орны өмнө тулгарч буй асуудлуудыг шийдэхэд оролцох боломж бий болсон” хэмээн өгүүлжээ. Тэрээр “Оросын эдийн засгийг өндөр хурдацтай өсч буйг” онцлон тэмдэглээд “2007 онд ДНБ ойролцоогоор 7.6%-ар өссөн нь их сайн үзүүлэлт боллоо. Үүнээс үүдэн бид бүхний боломж ч мөн өсөх учиртай” гэжээ. ОХУ-ын Ерөнхийлөгч “хэд хэдэн чухал арга хэмжээ авсныг” заагаад, тухайлбал, “улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд шууд нөлөө үзүүлэхүйц төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн Банк байгуулагдсан. Мөн өндөр технологи бүхий эдийн засгийн салбарт шинэчлэл явуулах зорилготой Оросын нанотехнологийн Корпораци, “Росатом”, “Ростехнологи” зэрэг корпорацийг байгуулж, эдгээр нэгжид нийт 600 тэрбум рубль төсөвлөсөн” гэж Путин онцолжээ.

“Техникийн паркуудыг байгуулж, тэдгээрийг суурилуулах бүсүүдийг тогтоож, шинжлэх ухааныг хөгжүүлэх үндсэн зорилтыг тодорхойлон, цаашдын 5 жилийн хөтөлбөрт суурь судалгаанд зориулж 255 тэрбум руб. хөрөнгө мөнгө төсөвлөжээ” хэмээн тэрээр хэлсэн байна. Мөн амбан захирагч нарт хандан жижиг дунд бизнесийг дэмжихийг уриалаад “Жижиг дунд бизнесийг дэмжих хууль батлагдаж, энэ салбарт тодорхой идэвхи санаачлага гарч байгаагийн нэг илрэл бол жилийн дотор жижиг бизнесийн салбарт 700 мянган шинэ ажлын байр бий болсон явдал юм” гэж Ерөнхийлөгч уг илгээлтдээ дурьджээ.

Мөн тэрээр телевизийн шууд ярилцлаганд орох үеэр 2008 онд ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн нэн тэргүүнд жижиг дунд бизнесийг хөгжүүлэхийн тулд Засгийн газраас тусгай хөтөлбөр боловсруулахыг чухалчилж, ОХУ-ын Эдийн засаг, худалдааны сайд Э.Набиуллинад уг

* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

ажлыг зохион байгуулахыг үүрэг болгон даалгасан байна. Учир нь одоогийн байдлаар Оросын эдийн засагт худалдаа үйлчилгээний салбар өргөн хөгжиж байгаа ба цаашид дэлхий дахинд өрсөлдөхүйц хүчин чадал бүхий эдийн засагтай болохын тулд Орос оронд аж үйлдвэрлэл, тэр дундаа жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх нэн шаардлагатай байгааг тэрээр онцлон тэмдэглэжээ.

Харин одоо зарим статистик тоо баримт авч үзье. Шинжээчдийн үзэж байснаар, 2007 он 2006 оноос онцын ялгаагүй жил болж, ОХУ урьд өмнөх шигээ эдийн засгийн өсөлт нь 6%-иас дээш гарчээ. Урьд онуудтай харьцуулбал, 2007 онд ДНБ-ий өсөлт хурдассан байна, тухайлбал, 2003 онд ДНБ 7.3%, 2004 онд 7.2%, 2005 онд 6.4%-иар өссөн бол 2006 онд 6.7%, 2007 оны эхний 9 сарын байдлаар, 7.8%-иар өсчээ. Энэ нөхцөлд 2008 онд ч мөн ДНБ-ий өсөлтийн динамик 2000 оны хямралаас хойш хамгийн өндөрт тооцогдож болохоор байна. Тухайн онд ДНБ 10%-иар өсч энэ нь Орос улс 1998 оны эдийн засгийн хямралаас гарч эдийн засаг сэргэсэнтэй холбоотой.

ДНБ-ий жинхэнэ хөдөлгүүр болсон худалдааны өсөлт 10 хувьд хүрсэн нь оросын иргэдийн тээврийн хэрэгслэл, ахуйн болон цахилгаан бараа худалдан авах чадвар өссөний нэгэн илрэл болжээ. Үүнд жижиглэн худалдааны хувь эхний 9 сарын байдлаар 8510.5 тэрбум рубльд хүрч 14.8 хувь болжээ. Иймд өнгөрөгч он жижиглэн худалдаанд их өгөөжтэй жил болсон гэж дүгнэж болохоор байна, жишээ нь, 2003 онд 8.8%, 2004 онд 13.3%, 2005, 2006 онуудад 12.8 хувийн тогтвортой өндөр өсөлтийг үзүүлж байжээ.

Хэрэв худалдаа нь эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болдог бол худалдааны өөрийнх нь гол хөдөлгүүр бол ард иргэдийн орлого юм. Учир нь Орост дундаж цалин мэдэгдэхүйц өсч байна, жишээ нь, 2005 онд сарын дундаж цалин 8555 рубль байсан бол 2006 онд 10636 рубль болсон байх жишээтэй. 2007 онд ч мөн эдгээр үзүүлэлт өсөх төлөвтэй байсан нь батлагдаж, эхний 9 сарын байдлаар дундаж цалин 13540 рубль болж жилийн өсөлт нь 25.4 хувь болсон байна. Үүний хажуугаар эрх баригчид дундаж цалинг 15000 рубльд хүргэх шаардлагатай гэж үзэж байгаа билээ. Ерөнхийлөгч Путин саяхан хэлэхдээ төсвийн ажилчдын болон цэргийн албан хаагчдын цалингийн хангамжийг 2008 оны 9 дүгээр сарын 1-ээс 7%-иар өсгөх байсныг 2 дугаар сарын 1-ээс 14%-иар өсгөх шаардлагатай гэжээ. Нэг хүнд ноогдох нийт мөнгөн орлого 2007 оны 9 дүгээр сар гэхэд 12901 рубльд хүрчээ (жилийн өсөлт нь 22.4 хувь). Оросын статистикийн албаны мэдээгээр оросын иргэдийн орлого амьдарч буй бүсээс хамааран цалингийн хэмжээ нь 7-9 янзын ялгаатай байна, тухайлбал, хүн амын орлогоор хамгийн баянд тооцогддог Ненецийн автономит тойргийн оршин суугчид дунджаар 30545 рублийн цалин

авдаг байхад Ингушетэд ердөө 3538 рубль байх жишээтэй. Цалингийн иймэрхүү зөрүүг эдийн засагч нар тухайн орны эдийн засгийн хөгжил жигд явагдахгүй байгаатай холбон тайлбарлаж байна. 2007 оны 9 дүгээр сарын байдлаар аж үйлдвэрлэлийн хамгийн өндөр 240%-ийн индексийг Сахалин муж үзүүлж, дараагаар нь Калининград муж 144.1%, Кабардин-Балкари, Адыгей, Марий Эл, Брянск муж, Агийн Буриадын автономит тойрог зэрэг нь 120%-ийн үзүүлэлттэйгээр удаалж байна. Гэвч эдийн засгийн өсөлтийн хажуугаар аж үйлдвэрийн уналт ОХУ-ын 14 субъектуудын эдийн засагт ажиглагдаж байгааг дараахь тоо харуулна: бараг 40%-иар Ингушетид ба Усть-Ордын Буриадын автономит тойрогт, 15%-иар Магадан, Воронеж мужуудад, Чукотск, Ямало-Ненецийн автономит тойргуудад гэх мэт. Хүн амын орлогын түвшин хамгийн өндөрт ордог газраар “түүхийн эдийн” гэгдэх бүсүүд тооцогддог, үүнд Чукотка, Сахалин, Магадан, Таймыр, Камчатка, Хабаровскийн хязгаар, Саха (Якут), Коми, Ненецийн автономит тойрог, Мурманск, Тюмень, Томск мужууд ордог ба эдгээр нь энэ байр сууриа өдгөө болтол хадгалсаар байгаа билээ. Албан ёсны мэдээгээр Чукоткад сарын дундаж цалин 16128 рубль бол Сахад 14077 рубль байдаг ажээ.

Ард түмний мөнгөн орлогыг дээшлүүлэхийн тулд эрх баригчдын авч буй үр дүнтэй арга хэмжээ болон ард иргэд олсон орлогоо бараа худалдан авч мөнгөө үрэх тэмүүлэл нь хуучны ЗСБНХУ-ыг санагдуулам түвшинд хүрчээ. Энэ тухай Сангийн сайд Алексей Кудрин одоогийн явагдаж буй эдийн засгийн өсөлтийн хурдацыг 1960-аад оны Зөвлөлтийн жишээтэй адилтгасан байна.

Гэвч аж үйлдвэрийн өсөлт эдийн засгийн өсөлттэй харьцуулахад тийм ч сайн түвшинд хүрсэнгүй. Хэрэв 2003-2004 онуудад аж үйлдвэрийн өсөлт жилийн 8%-иас илүү байсан бол 2005 онд эдгээр үзүүлэлт 4% болтлоо хоёр дахин унаж, 2006 онд энэ түвшинд хэвээр үлдсэн. Шинжээчид 2007 онд аж үйлдвэрийн өсөлт ойролцоогоор 5.0% байна гэж үзжээ. Харин 2008 онд аж үйлдвэрийн өсөлт 5.7% байна гэж шинжээчид тооцоолж байна.

Мөн 2007 онд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ дээд цэгтээ хүрч, нэг баррель нефть 100 ам.доллар давсан хэдий ч, оросын газрын тосны үйлдвэрлэл хангалтгүй байлаа. 2007 онд газрын тосны олборлолт ердөө 2.4% хүрч, байгалийн хийн олборлолт 1.3% болтлоо буурчээ. Үүнийг эрх баригчид тайлбарлахдаа өрнөд сибирийн орд газрууд ихээхэн хомсдон олборлолт муудаж, шинэ орд газрын олборлолт энэхүү хомсдлыг нөхөж байгаа гэжээ. Газрын тосны олборлолтын хэмжээ бага боловч дэлхийн зах зээлд газрын тосны үнэ огцом өссөний үр дүнд Орос орон газрын тосны сонгодог орны жишээ болж, үүнээс олсон орлогоороо импортын бүтээгдэхүүн, үүний дотор хүнсний бүтээгдэхүүн

ихээр авах болсон байна. 2007 оны 7 дугаар сар гэхэд л газрын тосны экспортын хэмжээ түрүү жилийнхтэй харьцуулбал өсч 4.4% хүрч, 1-7 дугаар саруудад экспортын хэмжээ 128.4 сая тонн болсон бөгөөд цаашид ч мөн өссөөр 6 дугаар сард 1 тонн газрын тос 474.7 ам.долл., 7 дугаар сард 507.1 ам.долларт хүрчээ. Үүний зэрэгцээ 2007 оны 1-8 дугаар саруудад ОХУ-ын гадаадаас оруулж ирэх барааны импорт 49.7% өсч, 101.055 тэрбум долл. хүрчээ. 2006 оны импортын хэмжээтэй харьцуулбал 32%-иар өсч 15.15 тэрбум долл. хүрсний дотор махны импорт 2007 оны 1-7 саруудад 20.6%-иар өсч 746.2 мянган тонн мах импортлож 1.825 сая ам.доллар зарцуулсан байна.

Засгийн газар болон Төв банкны сүүлийн хагас жилийн хугацаанд ч, цаашид ч толгойны өвчин нь инфляц хэвээр үлдэх бололтой. Засгийн газар захиргааны зарим арга хэмжээ авсан ч үнийн өсөлтийг тогтоож чадаагүй байна. Эдийн засаг, худалдааны Яамны сүүлийн дүнгээр инфляц 1.5 дахин өсч 2007 онд инфляцийн түвшин 12% болж 7-8%-иар өссөн мэдээ байна. Энэ нь 2006 (9.0%), 2005 (10.9%), 2004 (11.7%) онуудтай харьцуулбал өндөр байгаа бөгөөд 2003 оны 12.0%-ийн үнийн өсөлттэй дүйцэхүйц болжээ. Шинжээчдийн үзэж буйгаар инфляцийг тогтоохоор Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа богино хугацааны арга хэмжээ нь үнийн өсөлтийг зогсооход нэмэр болохгүйн дээр төсвийн зарлагын өсөлтийг бууруулах чиглэлээр авч байгаа арга хэмжээ зөвхөн цаасан дээр үлдэж байгаа хэмээжээ. Шинжээчдийн явуулсан инфляцийн талаархи судалгаанд 2007 онд инфляцийн түвшин 12.0% болно гэсэн нь биелэлээ олж, 2008 онд 9.8-9.4% байна гэж үзжээ. Гэвч энэхүү урьдчилсан таамаг гаргасан шинжээчид инфляцийн түвшин Засгийн газар болон Төв банкнаас гаргасан 7.5-8.5% түвшинд тогтоно гэдэгт итгэлтэй бус байна. Инфляцийн өсөлтөнд гол нь гадаад хүчин зүйлс нөлөөлсөн гэж Засгийн газар үзэж байна, тухайлбал, дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн өсөлт ОХУ-д хэт их нефтний орлого бий болох нөхцлийг хангаж доллар их хэмжээгээр урсан орж ирсэн, мөн Европын Холбооны Улсуудад хөрөнгө оруулалт буурсны уршигаар хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн нь Орост мөн үнийн өсөлтийг дагуулж, дэлхий даяар улаан буудайн үнэ огцом өссөн зэрэг шалтгааныг дурьдаж болохоор байна.

Оросын эдийн засаг сүүлийн 8 жилийн хугацаанд 1990-ээд оны үзүүлэлтүүдийг үлэмж хэмжээгээр давуулан, дэлхийн тэргүүлэх эдийн засаг бүхий “долоон” орны тоонд орж чаджээ. Энэ хугацаанд хуримтлагдсан гадаадын хөрөнгө оруулалт 7 дахин өсч, 2007 онд 82.3 тэрбум ам.долл. хөрөнгө оруулалт хийгдэж дээд амжилт тогтоосон байна. Оросын зах зээлийн хөрөнгө оруулалт 1999 онтой харьцуулбал 22 дахин нэмэгдэж 1 триллион 330 тэрбум долл. хүрч,

эдгээр үзүүлэлтээр Мексик, Бразил, Өмнөд Солонгос зэрэг орнуудаас тэргүүлж байна. Цаашид ч мөн хувийн өмчийг улсын секторт идэвхитэй ашиглахад эрх баригчид анхаарал тавих, аж үйлдвэр, нийгмийн салбарт хувийн өмчийн оролцоог аль болох нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

ОХУ зах зээлийн эдийн засгийн шаардлага бүхий шинжүүдийг бүрдүүлэн олон улсын эдийн засгийн болон худалдааны хамтын нөхөрлөлийн бүрэн эрхт гишүүн болсонтой холбогдуулан доорхи хурцадмал асуудлуудыг шийдэх шаардлага гарч байна: зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийн хангалтгүй хөгжил, ажиллах хүчний дутагдал, тэдгээрийн мэргэшил, эдгээр салбарын хоцрогдол цаашид стратегийн чухал алхмуудыг хэрэгжүүлэхэд садаа болох магадлалтай.

Экспортын түүхий эдийн хүчин зүйлийн өсөлтөөс бүрдсэн эдийн засгаас олон талт эдийн засаг руу шилжих нөхцөлд, үүнд тэргүүлэх үүрэг бүхий “эдийн засгийн мэдлэг” ба өндөр технологи бүхий аж үйлдвэрт тулгуурлан, эдийн засгийн өсөлтийн түвшинг тэр хэвээр нь тогтоож, инноваци дээр үндэслэсэн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал юм. Энэ нь оросын эдийн засгийн өрсөлдөх нөөц боломжийг өргөжүүлж, цаашид шинжлэх ухаан, боловсрол, өндөр хүчин чадал бүхий технологи зэргийг эдийн засгийн хөгжлийн шинэ эх үүсвэр болгон ашиглах боломж бий болгоно.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн санаачлагаар Оросын Эдийн засаг, худалдааны Яам “ОХУ-ын удаан хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг” 2020 он хүртэл боловсруулсан байна. Энэхүү Концепцийн гол санаа нь хүний хүчин зүйлд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх явдал юм, учир нь орчин үеийн инновацад тулгуурласан эдийн засгийн өрсөлдөх чадавхи нь мэргэжлийн боловсон хүчний хангалтаас ихээхэн хамаарах учиртай. Иймд боловсролыг шинэчлэх явц нь мэргэшсэн боловсон хүчинг тасралтгүй бэлдэх /long life learning/ дэд бүтцийг хөгжүүлэх, боловсролын технологийг нэвтрүүлэх, сургалтын байгууллагуудын хөрөнгө оруулалтын шинэ механизмыг бий болгох зэрэг үндсэн хэдэн чиглэлд явагдана.

Энэхүү Концепцид нийгэм-хүн ам зүйн асуудал, эдийн засгийн өсөлт, эрүүл мэндийн технологийн хөгжил зэрэг нь эрүүл мэндийн салбар, орон сууцны хангалтын асуудал, өмчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалт, дунд болон жижиг бизнес хөгжүүлэх асуудал, зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг олон талын асуудлыг тусгасан байна. Ерөнхийлөгч В.Путины санаачилсан “Нанотехнологи бүхий үйлдвэрлэлийн хөгжлийн стратеги”-ийн дагуу тухайн салбарт тохирох эрх зүй-зохион байгуулалтын дэд бүтцийг бий болгож, шинжлэх ухааны байгууллагууд болон дээд сургуулиудыг шаардлага

бүхий техникийн хангалт, боловсон хүчнийг бэлдэх арга хэмжээг авахаар болсон. Одоогоор Оросын нанотехнологийн Корпорацийг байгуулж байгаа нь цаашид инновацийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэхэд тус дэм болоход гол үүрэг гүйцэтгэх юм.

Зах зээлийн үр ашиг бүхий институцийг бий болгох, улс болон бизнесийн харилцан уялдаан дээр тулгуурласан оросын эдийн засгийн өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх, нийгмийн асуудлууд болон хөгжлийн бүсүүдийг байгуулах зэрэг нь ОХУ-ын хөгжил ба нэр хүндийг дэлхийн тавцанд цаашид улам бат бэх болгох үндэс юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Экономический рост в России превысил прогнозы. Обзор российской деловой прессы. www.regnum.ru/news/
2. Аналитики прогнозируют рост пропроизводства в РФ в декабре на 6,0%-консенсус-прогноз. Интерфакс, 2007-12-27
3. Интервью Министра Экономического развития и торговли Э.Набиуллиной об основных направлениях деятельности Министерства в будущем. www.economy.gov.ru/wps/
4. Народ-рубленосец. Журнал "Власть", №50 /754/, 2007-12-24
5. Экономика России с осторожным оптимизмом смотрит в будущее. www.mtpp.org/news/1/14/2008
6. Путин отмечает успехи в выполнении экономических задач послания-2007. Прайм-Тасс, 2007-12-27